



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/380

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас орон нутаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, алба хаагчидтай уулзалт зохион байгуулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд холбогдох ажлын хэсэг Хөвсгөл аймагт ажилласантай холбогдуулан гарсан зардалд 5,650,665 (Таван сая зургаан зуун тавин мянга зургаан зуун жаран таван) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 5,650,665 (Таван сая зургаан зуун тавин мянга зургаан зуун жаран таван) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН